# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2026 оны 06 сарын 12-ны өдөр — Баян-Өндөр сум

| № | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2025 оны эхний хагас | Хүрэх түвшин 2026 оны эхний хагас | Хэрэгжилтийн үр дүн үр дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, мэдээлэл, контентуудыг байгууллагын цахим сайт болон сошиал сүлжээнд сурталчлах; | Түгээсэн тоо, давтамж, хандалтын тоо | 9 | 13 | АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага, зэргийг тухайн албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр байгууллагын албан хаагчид болон олон нийтэд 13 удаа хүргэсэн. 1-р улиралд 5 удаа, 2-р улиралд 8 удаа Спортын холбоо, спортоор хичээллэгч иргэдэд авлигын эрсдлээс ангид байхыг уриалж байгууллагын мэдээллийн самбарт Авлигатай тэмцэх газраас өгч байгаа зөвлөмж, мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт 3 удаа байршуулж нийт 450 иргэнд сурталчилж ажилласан. | 100% |
| 2 | | 1,2.Байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр иргэд, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг 2-оос доошгүй зохион байгуулах, гарын авлага тараах; | Арга хэмжээний тоо | 2 | 2 | Байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2026 оны 06 сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж, иргэд, олон нийтэд чиглэсэн гарын авлага тараах 100ш тараасан; | 100% |
| 3 | | 1.3.Байгууллагын өргөдөл, гомдолын мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, | Байгууллагын албаны цахим хуудсаар болон мэдээллийн | 2 | 2 | Байгууллагын албаны цахим хуудсаар болон orkhon@sport.gov.mn мэйл хаяг, фэйсбүүк хуудсаар санал, хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэж ажилласан.<br>Байгууллагын албаны цахим хуудсаар болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | самбарт хариуцагчийн мэдээллийг байршуулсан байна. | | | мэдээллийн самбарт тайланг 1, 2-р улирлын тайланг байршуулсан | |
| | | 1.4.Өөрийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий шторк бэлтгэж, сурталчлан таниулах ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах; | Сургалтын тоо | 2 | 2 | 1.Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Улаанбаатар хотын Ёс зүйн академийн ерөнхийлөгч Ж.Ойнмандах "Ёс зүйтэй ажилтан" сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 28-нд зохион байгуулж байгууллагын ажилтан, албан хаагчид болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт холбоодын тэргүүн, нарийн бичиг, дасгалжуулагч нийт 36 хүн хамрагдсан.<br>2.2026 оны 04 дүгээр сарын 24-нд аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Алтанзулаас<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль<br>-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль<br>-Цахим болон залилах гэмт хэргээс сэргийлэх сэдвүүдээр сургалт зохион байгуулж 25 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 5 | 2.Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Байгууллагад шинээр орсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах; | Албан хаагчдын тоо | - | 3 | Тайланд онд шинээр ажилд орсон 3 албан хаагчийн 2 удаагийн танхимын, 2 удаагийн цахим сургалтад хамруулсан. | 100% |
| 6 | | 2.2.Хамтран ажилладаг спортын холбоод, клубуудын удирдлагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа ажлыг зохион байгуулах; | спортын холбоод, клубуудын тоо | 26 | 26 | Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Улаанбаатар хотын Ёс зүйн академийн ерөнхийлөгч Ж.Ойнмандах "Ёс зүйтэй ажилтан" сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 28-нд зохион байгуулж байгууллагын ажилтан, албан хаагчид болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт холбоодын тэргүүн, нарийн бичиг, дасгалжуулагч нийт 36 хүн хамрагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | 2.3.Орхон аймгийн Хууль, эрх зүйн хэлтэсээс авлигын эсрэг сургалт албан хаагчдад зохион байгуулсан байна. | Сургалтад хамрагдагсдын тоо | 1 | 1 | 2026 оны 04 дүгээр сарын 24-нд аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Алтанзулаас<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль<br>-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль<br>-Цахим болон залилах гэмт хэргээс сэргийлэх сэдвүүдээр сургалт зохион байгуулж 25 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 8 | | 2.4.Секц, дугуйланд суралцагч хүүхдүүдийн шударга байдлыг төлөвшүүлэх, нөлөөллийн арга хэмжээг дасгалжуулагч багш нартай зохион явуулна. | Хэрэгжилт хангагдсан байна. | - | Засаг даргын дэргэдэх өсвөрийн тамирчдад сургалт зохион байгуулсан байна. | 2026.05.22-ны өдөр Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн тамирчдад "Тамирчны сэтгэл зүйн бэлтгэл" сургалтыг сэтгэл зүйч Н.Алтанцоож (Ph.D), Ш.Шинэцэцэг нар зохион байгуулсан Орхон аймгийн 13 спортын төрлийн 154 тамирчин хамрагдсан. | 100% |
| 9 | 3.Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Спортын ажил үйлчилгээг спортын холбоод, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх, төсөв санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж буй байдалд хяналт тавих, ил, тод нээлттэй байдлыг хангуулах | Санхүүжүүлсэн тэмцээн, уралдааны тоо | 2 | 1 | Ажил үйлчилгээг спортын холбоод, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэхдээ 1 удаагийн гэрээ байгуулан санхүүжилтийг олгож, 82 ш тооцоо нийлсэн актаар ерөнхий нягтлан бодогч, хариуцсан мэргэжилтэнгүүд баталгаажуулан ажиллаж байна. | 80% |
| 10 | | 3.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд спорт холбоодуудын оролцоо, хамтын ажиллагааг | Үйл ажилла-гааны тоо | 1 | 1 | Тайлант онд спортын холбоодод авлигаас урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа зохион байгуулж, ЗГХА-БТСУХ-оос гаргасан “Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдье” уриан дор спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг спортын холбоод, багш, дасгалжуулагч нартай хамтран зохион байгуулж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх | | | | ажилласан. Нийт 120 гаруй хүн хамрагдсан. Биеийн тамирын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан спортын холбоо, фитнес клубын тэргүүн, нарийн бичиг нарт авлигаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалтыг 1 удаа зохион байгуулж нийт 10 хүн хамрагдлаа. | |
| 11 | | 3.3.Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ. | Хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн захиргааны удирдах албан тушаалд 2 албан хаагчийг журмын дагуу томилсон. | | Төрийн үйлчилгээний албан тушаалд 3 албан хаагчийг журмын дагуу 3 сарын хугацаатайгаар томилон ажиллуулж байна. | 100% |
| 12 | | 3.4.Шүгэл үлээх соёлыг байгууллагын хамт олонд төлөвшүүлнэ. | Сурталчилгаа хийсэн албан хаагчдын тоо | 40 удаа, 5 албан хаагч | 50 удаа, 6 албан хаагч | Шүгэл үлээх соёлыг байгууллагын хамт олонд төлөвшүүлэх зорилгоор албан хаагчдын дунд бүтээлч ажил хийх уралдааны зарлаж А зааланд нээлттэй мэдээллийн ил тод байдлын самбарыг албан хаагчид хийсэн.<br>Сурталчилгааг фэйсбүүк цахимаар 8 албан хаагчид, 50 гаруй удаагийн сурталчилгаа хийсэн байна. | 100% |
| 13 | | 3.5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжилтийг хангах, shilen.gov.mn сайтад мэдээллийг байршуулах, хуулийн хэрэгжилтийн хугацаанд үнэлүүлсэн байна. | Үнэлгээний дүн | 2025 онд 1-улиралд 47 үзүүлэлтийн 5640 онооноос 4925 оноогоор үнэлэгдэж 87,32%- 2-р улиралд 47 үзүүлэлтийн 5640 онооноос 5475 оноо авч 97,074%- | 98% | Мэдээллийг байршуулах, хуулийн хэрэгжилтийн хугацаанд байршуулсан байна.<br>1-р улиралд 4920 онооноос 4710 оноо 95,73% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 3-р улиралд 46 үзүүлэлтийн 5520 онооноос 5410 оноо авч 98,01%- 4-р улиралд 5640 онооноос 5685 оноо авч 97,07%тай тус тус үнэлэгдсэн байна. | | | |
| 14 | 4.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан нөхцөлийг арилгуулах, ил, тод байдлыг сайжруулах | 4.1.Цахимаар үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Тоо, дүн | - | 45 | Төрийн цахим хуудас gov.mn сургалтад 14 албан тушаалтангуудыг хамруулж, 45 мэдээ, мэдээлэл байршуулсан байна. | 80% |
| 15. | | 4.2.Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх спортын бараа материал бусад арга хэмжээний төлөвлөлтөд спорт холбоодын саналыг тусгах, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод мэдээлнэ. | Хамтран ажилласан арга хэмжээний тоо | 54 удаагийн арга хэмжээнд улсын болон орон нутгийн төсвөөс нийт 248,136,000 төгрөг зарцуулсан. | | Биеийн тамирын хэлтсээс ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан тэмцээн, уралдаан, нийтийг хамарсан алхалт, гүйлт, бүжиг, өдөрлөг зэрэг 6 удаагийн арга хэмжээнд 8132 иргэнийг хамруулж, орон нутгийн төсвөөс 148,847,000 төгрөг, улсын төсвөөс 4,040,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.<br>Спортын хэлтсээс насанд хүрэгчид, залуучууд, өсвөр, төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан тэмцээн, уралдаан, нийтийг хамарсан 52 удаагийн арга хэмжээнд улсын болон орон нутгийн төсвөөс нийт 104,916,000 төгрөг, Эрдэнэт мөнгөн өвөл арга хэмжээнд 35,041,000, үндэсний спортын арга хэмжээнд 45,000,000 сая зарцуулсан байна.<br>Нийт 257,803,000 төгрөг зарцуулсан байна. | 100% |
| 16. | | 4.3.Спорт холбоодоос сэтгэл | Судалгааны үр дүнд арга | Хамтран ажиллах | | Хамтран ажиллах гэрээ байгуулсан холбоодуудаас судалгааг жилийн эцэст авна | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэнамжийн судалгаа авч үйл ажиллагааг сайжруулж ажиллана. | хэмжээ авсан байна. | гэрээ байгуулсан 44 холбоодуудаас сэтгэл ханамжийн судалгааг авсан. | | | |
| 17. | | 4.4.Уралдаан, тэмцээний санхүүжилтийг ил тод нээлттэй байлгаж, байгууллагын вэб хуудсанд байршуулна. | Тоо, дүн | 39 | 16 | Уралдаан, тэмцээний санхүүжилтийг ил тод нээлттэй байлгаж, байгууллагын вэб хуудсанд эхний хагас жилд 16 тушаал байршуулсан. | 100% |
| | Эхний хагас жилийн хэрэгжилт | | | | | | 94,7% |

ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЛХАМСҮРЭНБААТАР
БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ-ХҮНИЙ НӨӨЦИЙН
АЖИЛТАН Ч.БОЛДЦЭЦЭГ